

ОРОС ХЭЛНИЙ БАГШ НАРЫН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

Хөтөлбөрийн товч танилцуулга

2012 оноос тус институт ОХУ-ын “Русский Мир Фонд”-ын санхүүжилтээр орос хэлний багш нарыг мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагаанд хамруулж байна. Тус фонд нь орос хэлний багш нарыг чадавхжуулах, орос хэл сургах үйл ажиллагааг дэмжих зорилготой хөтөлбөр бөгөөд 100 гаруй улсад үйл ажиллагааг явуулдаг.

Энэ хөтөлбөр 2013 оноос эхэлсэн бөгөөд орос хэлний багшийн мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтанд Эрхүүгийн улсын их сургуулийн мэргэжилтэн багш нар ирж хичээл заадаг. Мөн тус оноос орос хэлний багш нарыг тус сургуульд зуны сургалтанд хамруулж ирсэн, жилд 30-70 багш хамрагдсан байна. 2018 оноос ЕБС-д 5 дахь жилдээ ажиллаж байгаа багшийн мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтыг Эрхүүгийн Улсын их сургуульд зохион байгуулсан. Энэ сургалтад 40 багш хамрагдсан, сургалтын хугацаа 5 хоног.

Оролцогч орнууд:

- Монгол улс

Хөтөлбөрийн хүрээнд Монгол ба ОХУ улсын харилцан ойлголцол, нөхөрлөлийг бэхжүүлэн, орос хэлний багш нарын мэдлэг, үр чадварыг сайжруулж, багшийн хөгжлийг дэмжих сургалт-түршлага судлуулах үйл ажиллагааг голлон зохион байгуулж байна.

Хөтөлбөрт оролцогч талууд:

- Санхүүжүүлэгч: ОХУ-ын “Русский Мир Фонд”, БМДИ
- Зохион байгуулагч: Монгол Улсын БСШУСЯ
- Хэрэгжүүлэгч: Монгол Улсын Багшийн Мэргэжил Дээшлүүлэх Институт
ОХУ-ын Эрхүүгийн Улсын их сургууль

Тэтгэлгийн хэмжээ:

БМДИ - ОХУ-д сургалтанд хамрагдах багш нарын хоёр талын унааны зардал, Улаанбаатарт ирж хичээл заах багш нарын байр, хоол

Русский Мир Фонд- ОХУ-д сургалтад хамрагдах багш нарын мэндийн даатгал, сургалтын зардал, зочид бүүдлын зардлыг хариуцна.

Шалгуур үзүүлэлт

Мэргэжил дээшлүүлэх сургалтын хугацаа: *Жил бүр хоёр байгууллагын сургалтын хугацааг тогтоож сургалтыг зохон байгуулна.*

<p>Мэргэжил дээшлүүлэх сургалтын хугацаа</p>	<p>Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх</p>	<p>10 хоногийн сургалт-туршлага судлах үйл ажиллагаа</p>
<p>Шалгуур үзүүлэлт</p>	<p>Сонгон шалгаруулалтад оролцох багш нь доорх шаардлага, шалгуурыг хангасан байх;</p> <ol style="list-style-type: none"> 1. Багшлах эрхтэй байх 2. ЕБС-д 5-аас доошгүй жил багшилсан туршлагатай байх 3. Орос хэлний мэдлэг, харилцах өндөр чадвартай байх 4. Эрүүл мэндийн хувьд асуудалгүй байх 5. Виз авах шаардлагыг хангасан байх 6. Багшлах заах арга, үр чадвар өндөртэй байх 7. Сургууль, бүс нутаг, үндэсний хэмжээнд тодорхой амжилт үзүүлсэн байх 8. Багаар ажиллах чадвартай байх /Бусдын өмнөөс хариуцлага хүлээх чадвартай, бусдад эерэг нөлөөл үзүүлдэг байх/ 9. Багшийн ёс зүйтэй, соёлтой байх /Эерэг хандлага, харилцаатай байх/ 10. Хөтөлбөрт хамрагдаж ирээд орон нутаг, бүс, үндэсний түвшинд багшийг хөгжүүлэх үйл ажиллагаанд оролцох, манлайлах, нөлөөлөх, арга туршлагаа хуваалцах 	

Сонгон шалгаруулалтын үйл явц

1



Хугацаа тодорхой болохоор албан бичгээр мэдэгдэх (www.itpd.mn цахим хуусаар нийслэл, аймгийн болон дүүргийн БСУГ, Хэлтэст албан бичиг хүргүүлнэ)

2



Нийслэл, Аймаг, дүүргийн БСУГ, БХ-үүд шаардлага хангасан 1 багшийн нэр дэвшүүлж, холбогдох материалыг бүрдүүлж БМДИ-д хүргүүлнэ.

3



Материал нь тэнцсэн багш нартаа ярилцлага хийнэ. БСШУСЯ болон БМДИ-ийн цахим хуудаст хөтөлбөрт хамрагдах шаардлага, шалгуур хангасан багш нарын нэрсийг байршуулна.

4



Ярилцлагад тэнцсэн багш нарыг чиглэл өгөх сургалтад хамруулж, солилцооны хөтөлбөрт хамруулна. / Энэ үед болон холбогдох материал бүрдүүлэлтийг тухайн хүний хамт БМДИ хамтран зохион байгуулна. /